


# ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ЖИЛИЙН ТАЙЛАН 2023





## АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

КОМПАНИЙН БҮТЭЦ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ хороод, тогтоол, ирц

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ОХИН КОМПАНИ:  
ПРО МЕДИА НЕТВОРК ХХК ҮА ТАЙЛАН  
АНРИД ХХК ҮА ТАЙЛАН

ХАРААТ КОМПАНИ:  
МОНГОЛ ДИФАЙ ХХК ҮА ТАЙЛАН  
МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК ҮА ТАЙЛАН  
МПЕРС ХХК ҮА ТАЙЛАН  
ОРИ СТУДИОС ХХК ҮА ТАЙЛАН

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2023

МОНГОЛЫН АНХНЫ ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ  
ХУВЬЦААТ МЕДИА ХОЛДИНГ КОМПАНИ

## МЭНДЧИЛГЭЭ



ТУЗ-ийн дарга Г. Уянга



Гүйцэтгэх захирал Г. Бат-Эрдэнэ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та бүхнийхээ энэ өдрийн амар мэндийг эрье.

Улиран одогч 2023 он ТэнГэрЛиг Медиа Групп ХК-ийн хувьд салбартаа шнийг бүтээсэн, үзэгч, уншигчиддаа үнэ цэнийг бүтээсэн, амжилт бүтээлээр дүүрэн он байлаа.

ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

Бид маш хурдтайгаар ажиллан өөрсдийн өнгө төрхөө тодорхойлж, бүтэн брэндиг хийн, [www.tngr.media](http://www.tngr.media) албан ёсны вэбсайтаа хийсний сацуу хаалттай хүрээнд 5,941,457 ширхэг хувьцаа нэмж гаргах зөвшөөрлөө Санхүүгийн зохицуулах хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 8-ны өдрийн №344 тоот тогтоолоор авч, нийт хувьцааны 6,000,000 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж байсныг онцлууштай.

Түүнээс хойш тогтвортой үйл ажиллагаагаа өргөжүүлсээр, өдгөө бүрэлдэхүүндээ Про медиа нетворк ХХК (TenGer TV), Анрид ХХК (Unread media), Монгол телевиз (Mongol HD), Ори студиос ХХК, Мперс ХХК гэсэн охин болох хараат компаниудыг багтаан ажиллаж байна. Өнгөрсөн жилийн туршид Монголын Хөрөнгийн Бирж дээрх цорын ганц хэвлэл мэдээлэл, медиа чиглэлийн компани болох манай компанийн (MSE:TNGR) нийт 629 сая төгрөгийн 67 мянган ширхэг хувьцаа арилжаалагджээ.

Монгол HD телевизийн санаачилгаар 2020 онд үүсгэн байгуулагдсан “Ори Студиос” ХХК нь олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмж, мэргэшсэн багтай үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. Энэхүү төсөл нь дотоод, гадаадын кино, контентуудыг дуу, дүрсний өндөр чанартай бүтээж, үзэгчдэд хүргэх түүнчлэн Монголын соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах уран бүтээл туурвиж, үндэсний дархлааг тогтоох зорилготой.

Цар тахлын хүнд нөхцөлд үйл ажиллагаагаа эхлүүлсэн хэдий ч “Ори Студиос” төсөл маш амжилттай хэрэгжсээр байгаа юм. Тухайлбал, барилгын ажлын хувьд 2023 оны эхэнд А блокийн ган хийц угсрагдаж, оны эцэст тус блокийн өрлөгийн ажил бүрэн дуусаж, шилэн хана, хаалга хийгдэж, хаяавч бетон болон асфальтан зам цутгагдаж, явган хүний зам бүрэн дуусаад байна.

Оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой Анрид ХХК нь “Улаанбаатарын хамгийн таатай оффис”, “2030-Тогтвортой хөгжил”, “Би хэрхэн ажилладаг вэ?” зэрэг зах зээлд танигдсан, олон уншигчтай цуврал контентуудаа амжилттай бэлтгэн хүргэж, “Бэлгийн хөтөч”, “Журнал” зэрэг шинэ контентуудыг бэлтгэн хүргэлээ. Мөн залуу мэргэжилтнүүдийн хамгийн том цугларалт тодотголтой “Unplug 2023”, мэдээллийн технологийн комьюнитигийн хамгийн том эвент “DevSummit 2023”-ийг амжилттай зохион байгуулж, оролцогчид, хамтрагчдын тоо болон борлуулалтын дүнгээрээ дээд амжилт тогтоожээ. Анрид ХХК нь залуусын унших эрмэлзлийг өдөөх, чанартай агуулгыг түгээх зорилготойгоор “Unread Today” хэвлэмэл сониныг

Шинэ үеийн мэдээллийн хөтөч уриатай TenGer TV-ийн хувьд мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн агуулгаа улам баяжуулж, тогтвортой хөгжлийн чиглэлээр дагнасан “Цэнхэр толбо”, тээврийн чиглэлийн агуулгыг төрөлжүүлэн хүргэх “Цэг хооронд” мэдээллийн хөтөлбөрийг шинээр эрхлэн гаргав.

Мөн нийгмийн тулгамдсан асуудлаар баримтад суурилсан мэтгэлцээнийг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Үндэсний Мэтгэлцээний Лиг” оюуны реалити шоуг амжилттай зохион байгуулж, 10 гаруй их, дээд сургуулийн 40 гаруй баг 100 сая төгрөгийн төлөө өрсөлдөв. “Монголын Эдийн Засгийн Чуулган”, “Уул уурхайн 7 хоног”, “Гэгээн ширээт улсын төрийн тэргүүний айлчлал” зэрэг арга хэмжээг олон улсын болон үндэсний хэмжээний гол арга хэмжээнүүдийн шууд дамжуулалтыг бүрэн хариуцан ажиллаж, энэ чиглэлээр зах зээлд тэргүүлэгчид тооцогдох болжээ.

Амжилтаа ахиулсаар ирсэн түүхэн он цагийн хэлхээнд бидэнтэй хамт байсан нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, 2024 он бидний хувьд дараагийн үсрэнгүй амжилтын жил байх болно гэдэгт итгэл дүүрэн байна.

ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Группын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар:

Хараат компани: Монгол ТВ, ОриСтудиос, Мперс компаниуд хамаарагдаж буй.

Охин компани: ТэнГэр ТВ, Анрид

Яагаад?

- Нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж байгаа. Мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

Зорилго

- Монголын медиа салбарын анхны олон нийтийн нээлттэй хувьцаат, ил тод, хараат бус байдлыг хангасан, нэгдмэл редакцын бодлоготой групп компани болох
- Медиа салбарт шинэ жишиг тогтоож, зах зээлийг томсгон, үр нөлөөг ихэсгэж, түүгээрээ дамжуулан нийгмийг эерэг өөрчлөлтөд хөтлөх
- Уламжлалт болон дижитал медиа, OTT, технологийн инновациудыг нэгтгэж, хүн бүрт контентийн боломжит бүх төрлөөр, төхөөрөмжид үл хязгаарлагдан хүрэх


Алсын хараа

Эзэмших ирээдүй. Бүтээх ухамсар.  
(Өөрөө эзэмших ирээдүй. Ирээдүйгээ эзэмш.)



Үнэт зүйлс

- Хараат бус / Independent
- Ил тод, нээлттэй / Transparent
- Бүтээлч / Creative
- Инновацилаг / Innovative
- Хүртээмжтэй / Accessible

## КОМПАНИЙН БҮТЭЦ



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, %



2021/12/31	
Нэгжийн хаалтын ханш	20,000₮
Нийт хувьцаа	6,000,000
Нийт үнэлгээ	120 т6

2022/12/31	
Нэгжийн хаалтын ханш	16,900₮
Нийт хувьцаа	6,000,000
Нийт үнэлгээ	101 т6

2023/12/31	
Нэгжийн хаалтын ханш	10,000₮
Нийт хувьцаа	6,000,000
Нийт үнэлгээ	60 т6

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ЕРДИЙН ГИШҮҮД



Г.Уянга

#### Боловсролын байдал

- Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Банк санхүү
- Хартфорт дээд сургууль, MBA

#### Ажилласан байдал

- Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал
- Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал
- Грасрүүтс жижиг дунд бизнес дэмжих төв (НҮБ-ийн төсөл), Захирал



Г.Бат-Эрдэнэ

#### Боловсролын байдал

- Улс төр нийгэм судлал, Зүүн Англи Норвичийн Их Сургууль
- Удирдах албан тушаалтны хөтөлбөр, Харвард Бизнесийн сургууль

#### Ажилласан байдал

- Монгол Телевиз ХХК, Гүйцэтгэх захирал
- Монголын телевизүүдийн холбоо, УЗ-ийн дарга
- Монгол Телевиз ХХК, Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал
- Номсис ХХК, Ерөнхий захирал



Н.Мөнхнасан

#### Боловсролын байдал

- Санхүү эдийн засгийн удирдлага, Сан Францискогийн их сургууль
- Санхүүгийн инженер Магистр, Жорж Вашингтон их сургууль

#### Ажилласан байдал

- Монполимет Групп, ТУЗ-ийн дарга
- Дэлхийн банк төв оффис АНУ, Монгол улсыг хариуцсан эдийн засагч
- Монголбанк, Эдийн засагч
- ANN ХХК, Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ЕРДИЙН ГИШҮҮД



Ч.Батхүү

Боловсролын байдал

- Олон улсын харилцаа, Loughborough University
- Брикланд ХХК, Ерөнхий захирал

Ажилласан байдал



А.Ундрал

Боловсролын байдал

- Эдийн засаг МУИС
- Менежмент магистр, Львений Их сургууль

Ажилласан байдал

- ТэнГэр Телевиз, Гүйцэтгэх захирал
- Анрид ХХК, Гүйцэтгэх захирал
- Монголын үндэсний олимпын хороо, Нарийн бичгийн даргын орлогч
- UBS Телевиз, сэтгүүлч, редактор



Б.Золбоо

Боловсролын байдал

- Олон улсын нягтлан бодох бүртгэл, СЭЗИС
- Эдийн засагч, Plattsburgh коллеж

Ажилласан байдал

- Ард Санхүүгийн Нэгдэл, Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
- Ард Санхүүгийн Нэгдэл, Санхүү эрхэлсэн захирал
- Ард Менежмент, Гүйцэтгэх захирал
- Ард Менежмент, Хөрөнгө оруулалтын шинжээч
- Ард Секьюритиз ҮЦК, Хөрөнгө оруулалтын шинжээч

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ХАРААТ БУС ГИШҮҮД



В.Ганзориг

Боловсролын байдал

- Бизнесийн удирдлага, ХҮДС
- Бизнесийн удирдлага мастер, Австрали Нотр Дэймийн их сургууль
- Цахим бизнесийн удирдлага мастер, Японы олон улсын их сургууль

Ажилласан байдал

- BSP, УЗ-ийн дарга
- Медиа Групп, Гүйцэтгэх захирал
- Шунхлай Групп, Стратеги хариуцсан захирал



Б.Гантулга

Боловсролын байдал

- Российская Федерация
- Г.Москва Российская экономическая академия им Р,В,Плеханова

Ажилласан байдал

- Сүү ХК, Гүйцэтгэх захирал
- Ардын тэтгэврийн данс ХХК, Гүйцэтгэх захирал
- Анакс Аксис ХХК, Гүйцэтгэх захирал
- Моннис групп, Маркетинг хариуцсан захирал



Б.Наранзун

Боловсролын байдал

- Монгол Улсын Их Сургууль

Ажилласан байдал

- Лето Мьюзик ХХК, Гүйцэтгэх захирал
- АПУ ХК, ОНХХ хариуцсан захирал
- АПУ ХК, ХН хариуцсан захирал
- Шунхлай Групп, ОНХХ хариуцсан захирал


## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ хороод

### АУДИТЫН ХОРОО



В.Ганзориг Ч.Батхүү Б.Наранзун

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮ ЭРСДЭЛИЙН ХОРОО



Б.Золбоо Н.Мөнхнасан А.Ундрал В.Ганзориг

### ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО



Б.Наранзун Б.Гантулга Г.Уянга

## УДИРДЛАГЫН БАГ



**Г.Бат-Эрдэнэ**  
Гүйцэтгэх захирал  
**Д.Бат-Оюун**  
Санхүү эрхэлсэн захирал



**А.Ундрал**  
Тэнгэр ТВ, Анрид ХХК Гүйцэтгэх захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТОГТООЛ

4

ЭЭЛЖИТ БОЛОН  
ЭЭЛЖИТ БУС  
ХУРАЛ

4

ХОРООДЫН  
ХУРАЛ

15

ЭЧНЭЭ САНАЛ  
ХУРААЛТ

23

ШИЙДВЭРЛЭСЭН  
АСУУДЛЫН ТОО

Нэрс	Нийт хурлын тоо	Хуралд хамрагдсан байдал	Хувьцааны тоо
Г.Уянга	4	Биечлэн 4	1,940
Г.Бат-Эрдэнэ	4	Биечлэн 3, төлөөлөгч 1	692,292
А.Ундрал	4	Биечлэн 4	-
Н.Мөнхнасан	4	Төлөөлөгч 4	600,000
В.Ганзориг	3	Биечлэн 2, цахим 1, оролцоогүй 1	-
Б.Золбоо	4	Биечлэн 4	1,065
Ч.Батхүү	3	Биечлэн 1, цахим 2, оролцоогүй 1	-
Б.Наранзун	3	Биечлэн 1, цахим 2, оролцоогүй 1	-
Б.Гантулга	0	11/24-нд хараат бус гишүүнээр түр томилогдсон	-

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙГУУЛЛАГА

TenGer TV нь 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих чиглэлээр хэвлэл мэдээллийн салбарт бүтээлч санаачлагыг өрнүүлж, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлсэн тул “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага”-аар тодорлоо. Уг шагналыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлөөс гардуулжээ.

### ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ ХӨТӨЛБӨР

TenGer TV нь нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг дэмжин, долоо хоног тутмын эфирээрээ “Хүнсний хувьсгал” нэвтрүүлгийг үнэ төлбөргүйгээр цацлаа.

### ТЭРБУМ МОД

TenGer TV нь тогтвортой хөгжлийн үзэл санааг түгээн дэлгэрүүлж, сайн туршлагаудыг хуваалцан хэрэгжүүлэгчдийг алдаршуулах зорилготой “Цэнхэр толбо” мэдээллийн хөтөлбөрийг нэвтрүүлж эхлэв. Энэ хөтөлбөр нь “Тэрбум Мод” сангаас байгаль орчны сайн санаачлагыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт хэвлэл мэдээллийн сангийн дэмжлэгийг хүртсэн юм.

### АЛТАН ҮЗЭГ

Сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд явагддаг хамгийн том арга хэмжээ “Алтан үзэг 2023” наадамд TenGer TV, Unread Media компаниуд мэдээллийн ивээн тэтгэгчээр ажиллаж, “Мультимедиа контент”-ийн төрөлд шүүгчдийн багийг ахаллаа.

### БОЛОВСРОЛЫН ЭВЕНТ

Unread Media 2018 оноос эхлэн ХААН Банктай хамтран шинэ оюутнуудын хамгийн том цугларалт тодотголтой “Rise” арга хэмжээг зохион байгуулсаар ирсэн. Энэ жилийн арга хэмжээнд TenGer TV мөн нэгдэж, 1000 гаруй оролцогчтойгоор амжилттай зохион байгууллаа.

### МЕДИА ТҮНШ

Unread Media компани нь нийгмийн эерэг өөрчлөлтийг өртөөлж, залуусын оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг дэмждэг уламжлалтай. 2023 онд “Хүүхэд бүрд цэнхэр тэнгэр”, “Тогтвортой санхүүгийн долоо хоног”, YouthSpeak: залуусын дуу хоолой форум”, “ICT Expo 2023”, “Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган”, “Улаанбаатар” олон улсын медиа урлагийн наадам”, “Tomyo Talk 2023” арга хэмжээнүүдийн медиа түншээр ажиллалаа.

### TOYOTA SAFETY BOOK

Unread Media компани Toyota брэндтэй хамтран хүүхдийн зам тээврийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготой “Toyota Safetybook” төсөлд 2 дахь жилдээ хамтарлаа. Энэ ажлын хүрээнд замын хөдөлгөөний дүрмийг таниулах зорилготой комик номыг бүтээн нийт 5000 гаруй хүүхэд багачуудад түгээжээ.

### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Unread Media нийтлэлийн бодлогоороо дамжуулан уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл санааг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой ажилладаг. Энэ зорилгын хүрээнд ХААН Банктай хамтран бэлтгэдэг 2 долоо хоног тутмын цахим товхимол “2030”-ыг тасралтгүй бэлтгэн хүргэж, байгаль орчны чиглэлийн сайн туршлагаудыг алдаршуулах “Тогтвортой хөгжил” буландаа нийт 50 гаруй нийтлэлийг бичсэн байна.

### МОНГОЛ HD-ШИНЭЧИЛГЭЭ

Шинэчилгээ нэвтрүүлэг нь соёл,зөв хандлага, нийтийн тээвэр, хамтын амьдрал, байгаль эрүүл орчин, ногоон байгууламж, цэвэр агаар, эмх цэгцтэй хот гэх мэт нийгмийн асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрхэн зөв замаар бага өртөгтэй шинэ технологи ашиглан хэрхэн шинэчилгээ хийхийг харуулсан. Нийт 20 дугаар буюу 90,000 секундын нэвтрүүлэг Моод брэндийн үүсгэн байгуулагч Болд-той хамтран бүтээсэн байна.

### ТЭТГЭЛЭГ

Монгол телевиз Ирээдүйн санхүүгийн салбарт шударга залуусыг бэлтгэх зорилгоор 2006 оноос эхлэн жил бүр идэвх зүтгэлтэй оюутнуудыг сонгон шалгаруулж, сургалтын төлбөрийн тэтгэлэг олгодог “Шударга ёсыг бадраах сан”-д оюутны нийгмийн амьдралыг дэмжих, сурах үйлсэд дэмжлэг болох зорилгоор 1 сая төгрөг олгосон.

### ДАДЛАГА

Монгол Телевиз нь залуу хойч үеэ бэлдэн гаргах үйлсэд үнэ хувь нэмэр оруулдаг билээ. Энэ ажилын хүрээнд 2023 онд Авьяаслаг монголчууд шоу нэвтрүүлгийн хүрээнд 6 сарын хугацаанд СУИС,РТС,МУИС- уудаас 28 зураглаач,дууны найруулагч,сэтгүүлч оюутан залуус,Чимгээ нэвтрүүлгийн багт СУИС,РТС-ийн 8 сэтгүүлч, Suits буюу олон улсын форматаар Монголд анх удаа бүтээсэн кинонд 6 туслах зураглаач оюутан, Шинэчилгээ нийгмийн асуудлыг хөндсөн нэвтрүүлгийн хамт олон МУБИС-ийн 2 сэтгүүлч, Терминал1.0 чөлөөт ярилцалгын нэвтрүүлгэт МУИС-ийн 2 сэтгүүлч оюутан, Монгол ТВ нь 2023 ондоо нийт 46 оюутан залуусын хөгжил дэвшил, мэдлэг чадварт үнэтэй хувь нэмэр оруулан цалинтай дадлагажуулсан байна.

### ORI STUDIOS-ШУГАМЫН ӨРГӨТГӨЛ

Уурын зуухнаас Ургах наран хороолол хүртэл дулаан болон цэвэр усны шугамыг өргөтгөсөн 2 тэрбум төгрөгийн төсвийн ажил хийж гүйцэтгэсэн.

### ДУЛААНЫ ШУГАМЫН ӨРГӨТГӨЛ

120 диаметртэй дулааны шугамыг 200 диаметр болгон өргөтгөсөн бөгөөд нийт өргөтгөсөн шугамын урт нь 253,5 метр.

### ЦЭВЭР УСНЫ ШУГАМЫН ӨРГӨТГӨЛ

80 диаметртэй цэвэр усны шугамыг 150 диаметртэй болгон өргөтгөсөн бөгөөд өргөтгөсөн шугамын урт нь 58,6 метр юм.

Энэхүү томоохон ажилын үр дүнд өмнө нь гарч байсан зарим асуудлууд болох халаалтгүй болж хөлдөх, улмаар уурын тогоонд гал гарах эрсдэлтэй нөхцөл үүсэхээс сэргийлж чадсан бөгөөд Ургах наран хорооллын 496 айлын 9 байрын халаалалтын систем сайжирч тухайн хорооллын байрнуудын үл хөдлөх хөрөнгийн үнэ өссөн зэрэг эерэг үр дүнтэй байна.

### ХЭРЭГЛЭГЧИЙН ЗӨВЛӨХ

Онцгой бүтээлийг Ори-оос уриатай “Ори Медиа” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг “Хэрэглэгчийн зөвлөх” албан тушаалд ажиллуулдаг.



## ПРО МЕДИА НЕТВОРК ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Бизнес мэдээ, контент үйлдвэрлэл, шууд эфир

### Товч танилцуулга

Бид өөрсдийн шинэлэг, өвөрмөц форматтай нэвтрүүлгүүдээр дамжуулан ялгаатай үзэл бодол, олон талын дуу хоолойг нэгтгэж, хоорондоо ярилцан ойлголцох, мэдээллээ хуваалцах, мэдлэг туршлагаа солилцох боломжийг бүрдүүлсэн нээлттэй амьд харилцааг эрхэмлэн ажилладаг бөгөөд Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд анхаарал хандуулан, нийгмийн тэгш байдлын төлөөх дуу хоолой болохын сацуу Монголын санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө зүтгэж, үзэгчдийн соён гэгээрүүлэх эрхэм зорилготой

Хүний тоо

70+

### Алсын хараа

- Бизнес мэдээллийн гол эх сурвалж байна.
- Телевиз суурьтай медиа брэнд бий болгоно.
- Цаг үеийг мэдэрч, технологиор тэргүүлнэ.
- Нийгмийн тэгш байдлын дуу хоолой болно.

### Контент стратеги

- Гүн рүү шумбана
- Үнэт зүйлсээ эрхэмлэнэ
- Анхаарлыг татна
- Амьд байна
- Олон талт үзэл бодлыг хүндэтгэнэ



2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АЖИЛ ХЭРЭГЧ МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙН СУВАГ

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



January

Инвест Ховд арга хэмжээний медиа хамтрагчаар ажиллалаа



February

“Дата дуран” дататоньг зохион байгуулж эхлэв



March


“SciCon” шинжлэх ухааны комьюнитигийн хамгийн том арга хэмжээг зарлав



April

UB Forum арга хэмжээний шууд дамжуулалт, медиа брэндигийн ажлыг гүйцэтгэв

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



May

Үндэсний Мэтгэлцээний лиг 2023-ыг зохион байгуулав




June

Эмэгтэй гадаад хэргийн сайд нарын уулзалтын шууд дамжуулалтыг гүйцэтгэв



July


Монголын Эдийн Засгийн Чуулган 2023 арга хэмжээний медиа хамтрагчаар ажиллалаа



August

Ромын Папын айлчлалын “Медиа төв”-ийн ажлыг хариуцан гүйцэтгэв

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



## ОЛОН УЛСЫН МЭДЭЭ НИЙЛҮҮЛЭЛТ



## МЭДЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ



### ХОС АНКОР

Мэдээний хөтөлбөрийг баяжуулах үе шаттай ажлыг эхлүүлэв

### 24/7

Эфирийг 24/7 болгон өргөжүүлж, тасралтгүй байдлыг хангаж ажиллаж эхлэв

### ЗАХ ЗЭЭЛ

Зах зээл, хөрөнгийн захын мэдээг шинээр эхлүүлэв

## АНРИД ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Медиа, контент үйлдвэрлэл, эвент зохион байгуулах

### Товч танилцуулга

Unread Media бол оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой хосолмол медиа стартап юм. Контент гэдэгт бид өгүүлэмж (storytelling), арга хэмжээ (events), коммюнити (community)-г багтаадаг бөгөөд оновчтой агуулга, урамтай хэлбэрээр хэрэглэгчдийг гүнзгий суралцахад, далайцтай сэтгэхэд, илүүг бүтээхэд замчлах нь бидний чин эрмэлзэл.

### Хүний тоо

15+

Үйлдэлд хөтлөх санаанууд. Урам өгөх түүхүүд. Гэрэл тусгах цэгүүд. Гэгээ цацраах дүрүүд. Нарийвчлан харуулах өнцөг. Бүрэн зураглах ойлголт. Таниулах ёстой туршлага. Хүргэх учиртай мэдээлэл. Дэвшилтэт сэтгэлгээний охь. Бадрангуй бодлын оч.

Энэ бүхнийг бид хэрэглэгчдийн сонор, мэлмийд сорчлон хүргэхийг зорьдог. Ингэхдээ контентын бүх л төрөл хэлбэрийг сонгон хамгийн ойлгомжтой, шингээхэд хялбар аргыг ашигладаг билээ.

### Алсын хараа

Залуу мэргэжилтнүүд руу чиглэсэн Монголын тэргүүлэгч медиа байх

### Бидний бий болгосон үнэ цэн

Өнгөрсөн 9 жилийн хугацаанд бид шинэ үеийн залуу мэргэжилтнүүдэд зориулан хувь хүний хөгжил, технологи, гарааны бизнесийн орчинд өрнөж буй бүхий л мэдээ мэдээллийг хүргэхээр зорьсоор ирсэн нь Монголын гарааны бизнесийн орчинг төлөвшүүлэн хөгжүүлэхэд багагүй хувь нэмэр болжээ.

Үлгэр жишээ дүрүүд, ажлын арга барилаа төлөвшүүлэх, сурч хөгжих чиглэлээ хайж буй залуу мэргэжилтнүүдэд Unread хэзээд найз нь, хөтөч нь байсаар, болсоор ирсэн нь бидний ажлын гол үнэ цэн юм.



2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## БҮТЭЭГЧ ХҮМҮҮСТ ЗОРИУЛАВ

## НӨЛӨӨЛӨЛ

### СТАРТАП, ИННОВАЦЫГ ДЭМЖИВ

Эерэг медиа компанийн хувьд шинэчлэлтийг буухиалж, өөрчлөлтийг бүтээж буй мэргэжилтнүүдийг дэмжиж, тэднийг илүү олон хүнд таниулах үүрэгтэй. Энэ утгаараа Unread Media үүсгэн байгуулагдсан 2015 оноосоо мөс хагалагч, шинийг санаачлагч, тоглоомын дүрмийг эвдэгчид, үүсгэн байгуулагчид болон гарааны бизнес, арга хэмжээ, дэвшилтэт инновацын тухай бичиж, мэдээлсээр ирсэн.

Олны анхааралд тэр бүр өртдөггүй ч урдах ажлаа чанартай хийж байгаа эдгээр чимээгүй баатруудыг алдаршуулах ажлаа 2023 онд ч үргэлжлүүлж, сар тутмын “Онцлох стартапууд”, долоо хоног тутмын “Онцлох бизнес” тэргүүтэй нийтлэлүүдээрээ 60 гаруй бизнесүүдийг онцлов. Мөн “Би хэрхэн ажилладаг вэ?”, “Өртөөлөгчид”, “Журнал” гэсэн булангуудаар 100 орчим дүрийн ажлын арга барил, амьдралын түүхийг өгүүлжээ. Түүнчлэн “Шинэ жилийн бэлгийн хөтөч”, “Цагаан сарын бэлгийн хөтөч” нийтлэлүүдээр 150 гаруй үйлдвэрлэгчийн бараа, бүтээгдэхүүнийг уншигчдадаа танилцуулсан байна.

Мөн зургаа дахь удаагийн Unplug арга хэмжээний үеэр Unread Awards-ийн ээлжит эздийг тодруулав. 2016 оноос эхэлсэн, Монголын гарааны бизнесийн орчинд амжилт, нөлөөллөөрөө манлайлж буй шилдгүүдийг нэр дэвшүүлж, алдаршуулан урамшуулах зорилготой уг шагналын эздээр:

Шилдэг стартап: Metacog Metrics  
Шилдэг апп: Timely  
Шилдэг үүсгэн байгуулагч: Н.Хангал  
Шилдэг арга хэмжээ: SciCon нар тодров.

### УРАМ ЗОРИГИЙГ ТҮГЭЭВ

Үйлдэлд хөтлөх санаа түгээж, урам зоригоор цэнэглэх бол Unread-ийн амин сүнс. Бодит түүхээс илүү урам зориг түгээх зүйл үгүй. Энэ онд бид Теслагийн анхны Монгол инженерээс эхлээд нийтийн тээврийн асуудлыг шийдэж буй Орос залуу, Холливүүдийн одуудтай ажилладаг бүсгүй, Эверестийн оргилыг эзэлсэн уулчид, Мюнхенд хүрсэн дуу хоолойны эзэн зэрэг түүхүүдийг хуваацлаа. Эдгээр түүхүүд шинэ үеийн манлайлагчдад хүрч, тэдний урам зоригийг бадраан асаасан гэдэгт эргэлзэхгүй байна.

## НӨЛӨӨЛӨЛ

### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД УРИАЛАВ

“Тогтвортой хөгжлийн зорилгууд” бол хүн төрөлхтний 2030 он гэхэд хийж гүйцэтгэх ёстой “гэрийн даалгавар” юм. Эдгээр зорилгуудыг биелүүлэхийн төлөө хувь хүмүүс, албан байгууллагуудын сайн жишээг бусдад таниулж, мэдээлэл түгээх нь медиа салбарын үүрэг.

Тиймдээ ч энэ гинжин хэлхээнд холбогч, сэдэлжүүлэгч нь байхын тулд бид 2019 онд ХААН Банктай хамтран “Тогтвортой Хөгжил - 2030” цахим товхимлыг эхлүүлсэн билээ. Хоёр долоо хоног тутмын Пүрэв гарагт уншигчдад хүрдэг уг товхимол маань хэдийнээ 12 мянга гаруй захиалагчтай болж, нийтдээ 110 дугаарыг уншигчдад хүргээд байна.

Өнгөрөгч оны хувьд бид ногоон хөрөнгө оруулалт, сэргээгдэх эрчим хүч, боловсролын хүртээмж, цахилгаан хаягдал, дахин боловсруулалт, асрахуйн эдийн засаг зэрэг 17 зорилтын хүрээнд 50 гаруй нийтлэл бэлдэж, Монгол улсад тулгарч буй асуудал, учир шалтгаан болон залуу мэргэжилтнүүдийн дэвшүүлж буй шийдлийг онцолжээ.

## НИЙТЛЭЛ

2023 оны эцсийн байдлаар нийт 14 буланд 523 нийтлэлийг бэлтгэн хүргэв.

#### Булан

- Онцлох бизнес /Даваа/
- Techworm /Мягмар/
- Би хэрхэн ажилладаг вэ? /Лхагва/
- Мэдүүштэй /Пүрэв/
- Чөлөөт /Баасан/
- Номын тухай /Бямба/
- 7 хоногийн тойм /Ням/

#### Шинэ

- Өртөөлөгчид
- Тогтвортой хөгжил
- Тайлбарлах нь
- 10 ертөнц, 10 өнцөг
- Таатай оффис
- Зочинтой булан
- 8 минутын улс төр


## БЭЛГИЙН ХӨТӨЧ

Тэмдэглэлт баяр ёслолд зориулсан “Бэлгийн хөтөч”-ийн 5 дугаарт, нийт 500 брэнд, компани, үйлчилгээг онцоллоо.



## ЖУРНАЛ

Олон улсад амжилттай ажиллаж буй залуу мэргэжилтнүүдийн өдрийн хуваарь, онцлох үйл явдлуудыг цаг хугацааны дараалалтайгаар жагсаан хүргэдэг “Журнал” цувралыг эхлүүлээ.



## ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### UNPLUG

Зургаан удаа зохион байгуулагдаж, нийт 4000 гаруй залууст хүрээд буй Unplug арга хэмжээ 2023 оны 12-р сарын 12-ны өдөр “Hello Tomorrow” сэдвийн дор өрнөж, маргаашийн тухай ярилцсан юм. Ингэхдээ 60 жилийн түүхт Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын тайзнаа ажлын өдөр арга хэмжээгээ зохион байгуулсан нь энэ төрлийн үйл ажиллагаанууд дундаас ялгарах онцлог шийдэл байв. Энэ жилийн Unplug-т 22 илтгэгч, панелист, модератор, 28 байгууллага, 600 гаруй залуусын хамтаар маргаашийг тодорхойлох сэдвүүдийн талаар ярилцлаа. Мөн 2023 онд Unplug-аа төрөлжүүлж Unplug Khovd, Unplug Khan Bank гэхчлэн орон нутаг болон албан байгууллагад зохион байгуулсан нь тун ч амжилттай болсон билээ.



### MEF YOUTH

2023 оны долдугаар сард зохион байгуулагдсан 10 дахь удаагийн Монголын Эдийн Засгийн Чуулган өмнөх жилүүдтэй харьцуулахад цар хүрээ, ач холбогдол, зочид төлөөлөгчдийн тоо, зохион байгуулалтын хувьд дараагийн түвшиндээ хүрсэн юм. Тус чуулганд нийт 2000 гаруй зочид оролцсоноос 800 гаруй нь гадаад улсаас хүрэлцэн ирсэн байсан нь чуулганы зэрэг зиндааг илтгэж байв. Үүнээс гадна энэ жилийн арга хэмжээ зөвхөн үндсэн хэлэлцүүлгээс гадна дагалдах арга хэмжээтэй явагдсан ба Unread Media залууст зориулсан “MEF Youth” арга хэмжээний “Meet the Leader” хэсгийг зохион байгууллаа. Ийнхүү хоёр өдрийн турш 600 гаруй залуусыг цуглуулж, дөрвөн сайдтай залуу үеийн төлөөллийг уулзуулж, нээлттэй ярилцах талбарыг бүрдүүлэв.



## ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### DEVSUMMIT

Гурав дахь жилдээ зохион байгуулагдсан DevSummit арга хэмжээ 2023 онд Хиймэл оюун ухааныг үндсэн сэдвээ болгон хоёр өдрийн турш буюу тавдугаар сарын 27, 28-ны өдрүүдэд болж өнгөрсөн юм. Мэдээллийн технологийн салбарынхны хувьд хөөрөлдөх цэг, уулзах талбар нь болсоор ирсэн тус арга хэмжээг энэ жил MStars, HUB Innovation Center, Соёлын Төв Өргөө хэмээх гурван байршилд, таван тайзтайгаар зохион байгуулагдав. Эдгээр тайзнаа технологийн салбарын 50 орчим мэргэжилтэн гарч, өөрсдийн мэдлэг туршлагыг 800 гаруй оролцогчдод хуваалцсан юм.



### NAS SUMMIT

Дэлхийн даяар олон арван сая дагагчтай, үнэ цэнтэй контентуудаар шинэ үеийнхэнд нөлөөлж буй Nas Daily-ийн хамт олон энэ зун манай оронд зочилж, Nas Summit Mongolia арга хэмжээгээ зохион байгуулсан билээ. Нийт 30 гаруй илтгэгчтэй, долоон цагийн турш үргэлжилсэн уг үйл ажиллагааны зохион байгуулалтын багт Unread Media нэгдэж, контент бүтээх олон улсын туршлагыг дотоод 1000 гаруй контент бүтээгчдээ хүргэв.



## UNREAD WRAPPED

Редакцаас жил бүрийн эцэст гаргадаг тойм нийтлэлүүдийг “Unread Wrapped” гэсэн нэрийн дор нийт 8 сэдэвт гаргалаа.



## ХАКАТОН

Ард Санхүүгийн Нэгдэл, ХААН Банк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Нийслэлийн Бизнес Инновацийн Газартай хамтран нийт 8 хакатон зохион байгууллаа. Нийт 100 сая төгрөгийн шагналын санг залуу мэргэжилтнүүдийн

### MINI GAME ON ARD APP

72 цагийн хугацаанд мобайл тоглоомын санаа гарган түүнийгээ хөгжүүлж, демо хувилбар бэлтгэн шүүгчдэд танилцуулах дүрэмтэй уг хакатонд үндэсний хэв маягийг шингээсэн тоглоомоос эхлээд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн бэлгэдэл болсон чонын гол дүр бүхий тоглоом зэрэг сонирхолтой шийдэл, мэргэн санаагаар дүүрэн олон тоглоом бүтсэн юм. Ялагч багууд мөнгөн шагналаас гадна тус компанийн санал болгодог бүх бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дор багтаасан Ард Аппд өөрсдийн хөгжүүлсэн мобайл тоглоомыг байршуулах эрхийн эзэд болов.



### ХААН БАНК

Энэхүү хакатон нь ХААН Банкны зохион байгуулсан анхны нээлттэй хакатон гэдгээрээ онцлог байв. Олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтарч, өсөж хөгжих хүсэл эрмэлзэлтэй, санаагаа бодит үр дүн болгох зорилготой хэн бүхэнд нээлттэй явагдсан тус хакатоныг Unread Media хамтран зохион байгууллаа. Олон зуун оролцогчид хоёр сарын турш өрсөлдөж, кодын тэмцээн, цахим менторинг, шийдэл хөгжүүлэлт зэрэг цөөнгүй үе шатыг давсан ба шалгарсан 10 баг 72 цагийн хугацаанд хөгжүүлэлтээ хийн, шилдгүүдээ шалгаруулсан юм.



## ХАКАТОН

### ДАТА ДУРАН

HUB инновацын төв, Unread Media хамтран “Дата Дуран” хакатоныг хоёр дахь удаагаа зохион байгууллаа. Тоон өгөгдөлд тулгуурлан шийдэл боловсруулдаг уг хакатон 2023 онд цар хүрээгээ өргөжүүлж, илүү нарийвчилсан агуулгатай болсноороо онцлог байв. Хоёр сарын турш үргэлжилсэн тус хакатон нь Монгол Улс тэр дундаа Улаанбаатар хотод тулгарч буй, таван асуудалд төвлөрөн гарц, шийдэл боловсруулж, түүндээ хүрэх арга замыг нээн илрүүлэх зорилготой байв. Дата дуран хакатоны хүрээнд таван салбар дататон зохион байгуулагдаж, шилдэг 15 байрын (дататон тус бүрд шилдэг 3 байр) төлөө 100 гаруй баг өрсөлдөж, нийслэл хотод тулгамждаж буй таван асуудалд технологийн гарц гаргалгааг санал болгосон билээ.



### TECH SPRINT

Санхүүгийн зохицуулах хороо, Unread Media-тай хамтран санхүү, технологийн салбарын залуу мэргэжилтнүүдэд зориулан анх удаа “Санхүүгийн инновац” текспринт уралдааныг зохион байгуулсан юм. Санхүүгийн салбар дахь инновацыг дэмжих, олон нийтэд технологид суурилсан санхүүгийн зах зээл болон сэндбокс зохицуулалтын үйл ажиллагааг таниулах зорилготой Текспринтэд нийт 22 баг, 15 хувь хүн бүртгүүлснээс сүүлийн шатанд есөн багийн 34 оролцогч оролцов.



## ТӨСӨЛ



### TOYOTA SAFETY BOOK

Тоёота брэндийн хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд Toyota Safetybook төслөө тав дахь жилдээ үргэлжлүүлсэн ба Unread Media 2023 онд ч бас уг төсөлд хамтран “Тото Лулу хоёрын адал явдал” комик номынхоо үргэлжлэл бүлгийг бүтээсэн юм. Бид төслийн хүрээнд 10 хэсэг бүхий хүүхдийн зохиол, түүний зургийг урлаж, 5,000 хувь хэвлүүлэн, хотын захын дүүргүүдэд байрлах замын хөдөлгөөний эрсдэл бүхий 10 сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдад тараан, замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдлыг сурталчлан ажилласан билээ.

### “ИРЭЭДҮЙГЭЭ ТӨСӨВЛӨ”

Монгол Улсад төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхийн тулд Засгийн Газрын авч хэрэгжүүлж буй арга хэмжээг дэмжих зорилгоор, Европын Холбоо, Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Сангийн Яам, Unread Media компанитай хамтран “Ирээдүйгээ төсөвлө” аяныг 2021 оноос эхлэн хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлж 2023 онд төслийн хаалтаа хийсэн билээ. Уг аяны хүрээнд олон нийтэд төсвийн тухай ойлголт, цаашлаад Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын үйл явцад хэрхэн оролцож болох тухай чухал мэдээллүүдийг төрөл бүрийн контент, арга хэмжээнүүдээр дамжуулан хүргэв.



### “CHIP” ТӨСӨЛ

НҮБ-ын Хүүхдийн Сангийн “Уур амьсгалын өөрчлөлт ба цэвэр агаар” хөтөлбөрийн хүрээнд Пипл ин Нийд ОУТББ (People in Need), ToC Холбоо, ШУТИС-ын Барилга, архитектурын сургуулийн хамтран хэрэгжүүлж буй монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн нүүрсгүй шийдэл ЧИП багцыг олон нийтэд танилцуулах идэвхжүүлэлтийн төсөлд хамтран ажиллав Ирээдүйд цахилгаан үйлдвэрлэх, түгээх сүлжээний хүчин чадал хангалтгүй зэрэг асуудлуудыг зөв оновчтой дэд бүтэц боловсруулан шийдэж, улмаар цэвэр агаартай хот, улс болох боломж их бий. Уг том зорилгод ЧИП болон үүнтэй төст агаарын бохирдлыг бууруулах энгийн, хурдан бөгөөд үр дүнтэй шийдлүүд чухал хэрэгцээтэй гэдэгт бид итгэдэг.





## МОНГОЛ ДИФАЙ ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Программ хангамжийн үйл ажиллагаа, бизнесийн зөвлөгөө өгөх

### Товч танилцуулга

Монгол Дифай ХХК нь Монгол улсын анхны стэйблкойн (валютын нөөцөөр баталгаажсан үнэ цэнийг энгийн хэрэглээний валюттай аргамжсан криптовалютын төрөл) болох MONT-ыг 2021 оны 10-р сарын 29-ний өдөр зах зээлд гаргаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Монгол дифай ХХК нь MONT-ын зах зээлийн нийлүүлэлтийг хянаж, цаашдын хөгжүүлэлт болон интеграц хийх төслүүдийг удирдан чиглүүлэх замаар MONT-ын хэрэглээг олон улсын зах зээлд гаргах зорилготой

### Хүний тоо

3

### Алсын хараа

Крипто, блокчэйн ертөнцийг уламжлалт санхүүгийн ертөнцтэй холбох.

### Эрхэм зорилго

Бид MONT-ын зах зээлийн нийлүүлэлтийг хянаж, цаашдын хөгжүүлэлт болон интеграц хийх төслүүдийг удирдан чиглүүлэх замаар MONT-ын хэрэглээг олон улсын зах зээлд гаргахаар зорин ажиллаж байна.

MONT нь Монгол Төгрөгтэй аргамжсан, Төгрөгийн нөөцөөрөө баталгаажсан стэйблкойн. MONT стэйблкойн нь виртуал хөрөнгө болон бусад валют руу түргэн шуурхай, чөлөөтэй хөрвөж виртуал хөрөнгийн арилжааг хялбарчилна.



2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ТАЙЛАН

Лист хийгдсэн биржүүд:



Үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш idax.exchange, Trade.mn, denode.io, Corex.mn биржүүд дээр лист хийж арилжаалагдаж байна.

## MONT (Mongol Tether)-ийн талаар

MONT нь Монгол Төгрөгтэй аргамжсан, нөөцөөрөө баталгаажсан стэйблкойн

MONT стэйблкойн нь виртуал хөрөнгө болон бусад валют руу түргэн шуурхай, чөлөөтэй хөрвөж виртуал хөрөнгийн арилжааг хялбарчилна.



## ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

Технологийн хамтрагчид:



Хамтран ажиллаж буй блокчэйн төслүүд:



Хамтран ажиллаж буй финтек байгууллагууд:



ДЭЛХИЙН ШИЛДЭГ КОНТЕНТУУДЫГ  
НЭГ ДОР ҮЙЛДВЭРЛЭГЧ МОНГОЛЫН АНХНЫ  
АЗИЙН ШИЛДЭГ ТЕЛЕВИЗ



ХАМГИЙН ОЛОН СОШИАЛ  
ДАГАГЧ, ХАНДАГЧТАЙ ТЕЛЕВИЗ



ХАМГИЙН ОЛОН ЦАГИЙН ШУУД  
ЭФИР НЭВТРҮҮЛДЭГ ТЕЛЕВИЗ



## МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК

Үйл ажиллагааны чиглэл  
Медиа салбарыг түүчээлэгч Монгол Телевиз

Товч танилцуулга  
“Монгол ТВ” телевиз нь Монголд анх удаа оюуны өмчийн онцгой эрхтэйгээр дотоод гадаадын бүхий л контентуудыг худалдан авч, дуу дүрсний өндөр чанартайгаар үзэгчдэд хүргэхээс гадна дэлхийн томоохон шоу нэвтрүүлгийн форматаар Монголд шоу нэвтрүүлгүүдийг амжилттай бүтээж, Монголын нэвтрүүлгийн стандартад шинэчлэл хийж байна.

Хүний тоо  
170+

- Үнэт зүйл
- Шударга үнэн;
  - Чин сэтгэл;
  - Хичээнгүй зүтгэл;
  - Чанд хариуцлага;

Эрхэм зорилго  
Чанартай, сонирхолтой бүтээлийг ёс зүйг эрхэмлэн туурвиж, түгээж, олон нийтийг соён гэгээрүүлэх замаар нийгэмд эерэг өөрчлөлт бий болгон, салбартаа түүчээлэн тэргүүлж, үнэт өв үлдээнэ.

Алсын хараа  
Уран бүтээлч сэтгэлгээг тэтгэн, бүтээн туурвиж хөгжин чадваржих орчныг бүрдүүлэгч удирдлагатай, мэргэжлийн уран чадвар, чанд хариуцлага бүхий оргилсон эрч хүчтэй, сэтгэл хангалуун бүтээлч хамт олонтой, мэдлэг боловсрол, гоо зүй, ёс зүйг дээдлэн шилдэг технологиор туурвисан бүтээлтэй, ашигтай, итгэлтэй бодит үнэ цэнийг хүртэгч харилцагчтай, тогтвортой ил тод байгууллага байхад оршино.

- Гүн хүндлэл;
- Урам зориг;
- Цог Золбоо;
- Бүтээлч сэтгэлгээ;
- Хөрвөх чадвар;
- Эерэг хандлага

ОЮУНЫГ ТЭТГЭЖ, ЖАРГАЛ БЭЛЭГЛЭНЭ

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



### APPRENTICE MONGOLIA

Бизнесийн номер 1 шоу нэвтрүүлгийн 2 дахь улирлыг эхлүүлэн Монгол улсад амжилттай дахин нутагшуулж олны хүртээл болголоо


### MONGOLIA'S GOT TALENT

Авьяаслаг Монголчууд шоу нэвтрүүлгийн 4-р улирлыг амжилттай зохион байгуулж үндэсний хэмжээний 4 дэх ялагчийг тодрууллаа



### АРДЫН БУЙДАН

Гэр бүлийн хамгийн үзүүштэй, олон мянган үзэгчдийн хүртээл болсон "Ардын буйдан" нэвтрүүлгийн 15/3-р улирлыг амжилттай үзэгчдийн хүртээл болгосон



### ӨНӨӨ ӨГЛӨӨ

2023 онд Нийт 62184 минутын шууд эфир буюу 448 дугаар үзэгчдэдээ хүргэжээ. Энэхүү нэвтрүүлэг нь 2012 оноос эхлэн бүтэн 12 жил тасралтгүй хүрч байна



16%

Ярилцлага болон шууд нэвтрүүлгийн продакшн

15%

Мэдээ болон нийгмийн нэвтрүүлгийн продакшн

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



### ХАР ХАЙРЦАГ

Үнэн бодит мэдээллийг хөдөлшгүй баримт нотолгоотойгоор хувь хүн болон албан тушаалтны байр сууриас бэлтгэн хүргэдэг ярилцлагын нэвтрүүлэг нь 2015 оноос эхлэн бүтэн 8 жил тасралтгүй хүрч байна

### НҮҮДЭЛ ШИЙДЭЛ

Нийгэм, улс төр, эдийн засаг зэрэг бүхий л салбар дахь асуудлуудыг хөндөж, олон талт эх сурвалжид тулгуурлан шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилготой хэлэлцүүлгийн нэвтрүүлэг бүтэн 11 жил тасралтгүй хүрч байна




### TERMINAL 1.0

Нийгмийн анхаарал, мэдээлэлд хамгийн ойрхон, үйл явдал онцлох сэдэв, шинэлэг бүхний анхдагч эх сурвалжаар дамжуулан хүргэх, ажлын өдрүүдэд шууд явагдах шинэ төсөл 2023 оны 6 сараас эхлэн 249 дугаарыг бэлтгэн хүргэлээ

### SUITS

NBC Universal-н бүтээл SUITS олон ангит киноны Монгол хувилбарыг албан ёсны эрхтэйгээр нийт 12 ангийг Монгол Солонгосын уран бүтээлчид хамтран бүтээлээ.



43%

Кино гадаад нэвтрүүлгийн продакшн

14%

Нэвтрүүлгийн продакшны шоу нэвтрүүлгүүд

## МПЕРС ХХК



### Үйл ажиллагааны чиглэл

Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрдийн дагуу (лотто)

### Товч танилцуулга

МПЕРС ХХК нь 2019 онд байгуулагдсан ба 2022 онд эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл аван 2022 оны 11 сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Бидний зорилго Монголын хамгийн том лотто болох зорилгыг тээн одоогийн байдлаар Монгол ТВ болон Ард Санхүүгийн Нэгдэлийн Ард Апптай хамтран идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

### Зорилго

Монгол улсад олон улсын стандартад нийцсэн лоттог нутагшуулах

### Хүний тоо 3




ДЭЛХИЙН ЖИШИГТ НИЙЦСЭН, ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТЫН ДАГУУ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ 6/42  
ЛОТТО



2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- Нийт 60 тохиролд 20 мянга гаруй харилцагч оролцсон. Борлуулагдсан тасалбар 70 мянга орчим. Нийт мөнгөн дүнгийн шагналыг 2,100 хүн авсан байна. Жакпот ₮440 сая болсон байна. Долоо хоногт дунджаар 4,000 тасалбар зарагдсан.



- Вебсайт болон апп-тай болов

Давуу тал, боломж:

1. Илүү хялбар
2. Түргэн шуурхай
3. Илүү ойлгомжтой
4. Монголын нэгдсэн лоттон платформ болох боломжтой

Web site



Mini App



Гүйцэтгэл



## АРГА ХЭМЖЭЭ



Хөрөнгө оруулагч үндэстэн чуулганд анх удаа  
600+ оролцогч  
1,000 тасалбар зарагдав



Бид илүү байж чадна аяны хүрээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 119, 29-р дунд сургуулийн нийт сурагчдад Хүүхдийн хадгаламж Ард Санхүү Нэгдлийн хувьцаа эзэмшүүлэв




ICT EXPO 2023 анх удаа  
300+ оролцогч  
450 тасалбар зарагдав



# ORISTUDIOS

2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АЗИД ТЭРГҮҮЛЭГЧ, ДЭЛХИЙД 29-Т  
ЭРЭМБЭЛЭГДЭХ, ОЛОН УЛСЫН ISO TC 36 СТАНДАРТЫН  
КИНО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР



МОНГОЛ СОЁЛ УЛАМЖЛАЛАА СУРТАЛЧИЛАХ, КИНО УРЛАГИЙН  
САЛБАРЫГ ДЭЛХИЙН ТҮВШИНД ГАРГАХ ТӨСӨЛ



## ОРИ СТУДИОС ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Бүтээлч үйлдвэрлэл, кино контент, түрээс, эвент

Товч танилцуулга

Бид олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу дуу, дүрсний өндөр чанартайгаар бүтээж, үзэгчдэд хүргэх, Монгол соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах, уран бүтээл туурвиж, үндэсний дархлааг тогтоох зорилготой.

Хүний тоо

10+

Ори Студиос төсөл нь эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэлтэй Монгол хүнийг хөгжүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх түүнчлэн үндэсний хэв шинж, үзэл бодол, гүн ухаан, гоо зүй, соёл, амьдралын хэв маягийг харуулсан ОУСтандартад нийцсэн бүтээл туурвих зорилготой кино болон контент үйлдвэрлэгчдийн нэгдсэн медиа хабыг байгуулж, ирээдүй хойч үедээ оюуны өвийг үлдээнэ.

Алсын хараа

Чанартай уран бүтээлээс соён гэгээрэл, мэдлэг, соёлын дархлаа, үнэт зүйлсийг бий болгон бүтээлч соёлыг цогцлооно.

Үнэт зүйлс

- Чанартай бүтээл;
- Чин сэтгэл;
- Ёс зүй;
- Хамтын зүтгэл;
- Үзэгч;
- Оюуны өмч;
- Нийгмийн хариуцлага;
- Төгөлдөршил

ТА ӨӨРИЙН САНААГАА БҮТЭЭЛ БОЛГО  
ОРИ СТУДИОС ЭНЭ БҮГДИЙГ БОЛОМЖТОЙ БОЛГОНО



ORI STUDIOS



## ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



### CYBER WHITE FESTIVAL

1 өдөр  
800+ оролцогч  
4 тайз, хөтөлбөр  
10+ сайн дурын ажилтан



### MARCH 8TH & 18TH EVENT

700+ оролцогч  
Шууд дамжуулалт  
Тайз засал  
Уран бүтээлчид



### MONGOL TV NYP


180+ оролцогч  
Тайз засал  
5 цагийн хөтөлбөр

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМУУД



### GREEN INVESTMENT

Анх удаа  
200+ гаруй хөрөнгө оруулагч  
1 өдөр



### INVESTOR NATION

2 дахь жилдээ  
300+ хөрөнгө оруулагч  
2 өдөр



### HONGKONG FINTECH WEEK

Хөрөнгөтөн форумд оролцон бонд болон төслөө танилцуулав.

## ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА



### ХҮЛЭЭН АВСАН ЗОЧИД

15+ ОУ-ын зочид төлөөлөгчдийг хүлээн авч студиэ танилцуулан шинэ төслүүд дээр хамтарч ажиллах эхлэл тавигдлаа.



### КАННЫН КИНО НААДАМ

Каннын кино наадамд оролцож кино төслөө танилцуулан хамтын ажиллагаануудын эхлэл тавигдлаа.



## ГАДНА ЦАХИЛГААНЫ УГСРАЛТЫН АЖИЛ



## ДОТОР ЦАХИЛГААНЫ УГСРАЛТЫН АЖИЛ



## ДОТОР ХАС ЦБУ



## ТАЛЕНТ ХАБ ТӨСӨЛ

500+ talents


- Actors & Extras
- Filmmakers & Production team
- Stunt team
- Models
- Dancer's & Circus performers
- Music & Musical
- Voice actors & Host



 Kh. Unurbayasgalan /D.o.P /	 L. Batbileg /Art department/	 G. Batjargal /Sound mixer/	 J. Sengedorj /Filmmaker/	 E. Khos-Erdene /Make up artist /	 G. Erdenebaatar /Content creator/	 DELKHII /Music band/
 OX STUDIOS /Crew-8/	 MODELS agency /47 models/	 DUMOND /Dance crew-15/	 DDANCE LAB /Dance crew - 16/	 MONGOL STUNT /Team - 52/		
 CUBI UNIVERSITY +80 Students						 MUSIC +50 Students

## ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД





**ЭЗЭМШИХ  
ИРЭЭДҮЙ**

**БҮТЭЭХ УХАМСАР**

**MSE: TNGR**



**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН****ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд****Дүгнэлт**

Бид Тэнгэрлиг Медиа Групп ХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЭЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЭЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг**

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

**Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг**

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга

\* "Хүлээгдхүүнүү аудит" ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,  
Бага тойруу /14201/, Самбуугийн гудамж 6-р барилга 4 давхар, 402 тоот  
Утас/Факс: +(976)-7014 0505

материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийн өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсоход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:



М.Гүрраваа  
Гүйцэтгэх захирал  
Хүлээгдхүүнүү Аудит ХХК

2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр  
Монгол Улс, Улаанбаатар хот

\* "Хүлээгдхүүнүү аудит" ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,  
Бага тойруу /14201/, Самбуугийн гудамж 6-р барилга 4 давхар, 402 тоот  
Утас/Факс: +(976)-7014 0505

## ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2023

## ТУСДАА САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДСАН

Санхүүгийн тайлан / сая.төг	2022	2023	YoY	YoY %
Мөнгөн хөрөнгө	5	3	(2)	(40%)
Дансны авлага, Бусад авлага, Татвар НДШ авлага	1,187	88	(1,099)	(93%)
Урт хугацаат ХО	13,433	16,305	2,872	21%
Үндсэн хөрөнгө	5	1	(4)	(80%)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,704	2,014	(1,690)	(46%)
Нийт хөрөнгийн дүн	18,334	18,411	77	0.4%
Дансны болон бусад өглөг	197	361	164	83%
Татвар, НДШ өглөг	199	255	56	28%
Хойшлогдсон татвар өр	96	1	(95)	(99%)
Урт, богино хугацаат зээл болон хүүгийн өглөг	1,625	-	(1,625)	(100%)
Бусад богино, урт хугацаат өр	2,733	2,521	(212)	(8%)
Эзний өмч	13,484	15,273	1,789	13%
Өр ба эзний өмчийн дүн	18,334	18,411	77	0.4%

## ТУСДАА ОРЛОГЫН ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДСАН

Орлогын тайлан / сая төг	2022	2023	YoY	YoY %
Үйл ажиллагааны орлого	44	15	(29)	(66%)
Бусад орлого	-	-	-	-
Нийт зардал	903	293	(610)	(68%)
Ерөнхий удирдлагын зардал	561	248	(313)	(56%)
Борлуулалт, маркетингийн зардал	27	-	(27)	(100%)
Санхүүгийн зардал	315	45	(270)	(86%)
Бусад зардал	-	-	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	125	206	81	65%
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	(734)	(71)	663	(90%)
Татвар	-	(74)	(74)	-
АШИГ / АЛДАГДАЛ	(734)	3	737	(100%)

## ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДСАН

Мөнгөн гүйлгээний тайлан / сая төг	2022	2023	YoY	YoY %
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(300)	103	403	(134%)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,099)	74	1,173	(107%)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	183	(179)	(362)	(198%)
Зээлээс хүлээн авсан мөнгө	185	-	(185)	(100%)
Зээл урьдчилгаанд төлсөн мөнгө	(2)	(179)	(177)	8,850%
Төрөл бүрийн хандив	-	-	-	-
Цэвэр мөнгөн гүйлгээ	(1,216)	(2)	1,214	(100%)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	1,221	5	(1,216)	(100%)
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5	3	(2)	(40%)

## САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД сая.төг



# MSE: TNGR

[www.tngr.media](http://www.tngr.media)